



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 412

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Архангай аймгийн Засаг даргын 2021 оны нөөц хөрөнгөөр бий болсон 43,072,910.00 (дөчин гурван сая далан хоёр мянга есөн зуун арван) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Архангай аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин, Архангай аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга С.Оюунбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.5.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132003048

2022.09.29 22-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 09 дүгээр сарын 22 өдрийн
44 дугаар тогтоолын хавсралт

**АРХАНГАЙ АЙМГИЙН УС, ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН
ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалта д орсон огноо	Х/н	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Балансын үнэ
Архангай аймгийн УЦУОШТ						
1	Цэвэр бохир усны шугам	12/21/2021	м	120	43,072,910.00	43,072,910.00
Нийт дүн			м	120		43,072,910.00 (дөчин гурван сая далан хоёр мянга есөн зуун арав)